# МОНГОЛ ХЭЛ

# 2010

## ХУВИЛБАР А

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Тогоруу

Хос тогоруу сайр даган хөлөө дээр дээр өргөн зэгзэгнэн алхана. Би сайрын хөх хайрган дунд тогорууны өндгийг үзэлгүй сүүдрээ хүргэчих вий гэхээс зүрх эмзэглэнэ.

Хөөрхий нялх үрийг нь сүүдрээрээ хиртүүлэхүй намайг хараана гэхээс өвөөгийн хэлсэн үг өр зүрх өвтгөнө. “Ай даа, хүү минь, тогорууг уурлуулж болдоггүй юм. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан“ гэж захидаг сан.

Өндөр хөх тогорууг өнөөдөр би их л ойроос хараад өрөвдөв. Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү? Лав үгүй байх аа. “Хүнд муу биеэрээ дэлхийг цөмлөчих вий гэсэн шиг ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ“ гэхээс өвөөгийн үгэнд үл итгэв.

Миний бодлыг батлах шиг мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуй.

*(Н.Өлзийбат)*

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой.
   1. Хоёр тогоруу зэгзэгнэн айсуй
   2. Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү?
   3. Ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ.
   4. Хос тогоруу зэгзэгнэн алхана.
   5. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан гэж захидаг сан.

   A. 1, 5, 2, 3, 4 B. 1, 5, 3, 2, 4 C. 4, 5, 2, 3, 1
   D. 4, 5, 3, 2, 1 E. 2, 4, 3, 5, 1
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?
   A. Хүний зүйл B. Ургамлын зүйл C. Амьтны зүйл
   D. Гариг эрхсийн зүйл E. Хүний бүтээсэн зүйл
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу.
   A. Тоочимж B. Эргэцүүлэмж C. Тайлбарламж
   D. Хүүрнэмж E. Учирламж
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?
   A. Албан бичгийн найруулга B. Уран зохиолын найруулга
   C. Сонин нийтлэлийн найруулга D. Ярианы найруулга
   E. Эрдэм шинжилгээний найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.
   A. Тогорууны тухай B. Ахмадын сургаалыг дагаж мөрдөх тухай
   C. Элбэрэл хайрын тухай D. Байгалийн тухай
   E. Сониуч хүүгийн тухай
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Өндөр хөх тогорууг өнөөдөр би их л ойроос хараад өрөвдөв.
   B. Дэлхийг цөмлөчих вий гэсэн шиг ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ.
   C. Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан.
   D. Тогорууны өндгийг үзэлгүй сүүдрээ хүргэчих вий гэхээс зүрх эмзэглэнэ.
   E. Өвөөгийн үгэнд үл итгэв.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
   A. “Хос тогоруу... зүрх эмзэглэнэ“, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан“, “Өндөр хөх тогорууг... үл итгэв“, “Миний бодлыг... зэгзэгнэн айсуй“ гэсэн 4 цогцолбор
   B. “Хос тогоруу...захидаг сан“, “Өндөр хөх тогорууг... зэгзэгнэн айсуй“ гэсэн 2 цогцолбор
   C. “Хос тогоруу... зүрх эмзэглэнэ“, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан“, “Өндөр хөх тогорууг... зэгзэгнэн айсуй“ гэсэн 3 цогцолбор
   D. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
   E. “Хос тогоруу... зүрх эмзэглэнэ“, “Хөөрхий нялх үрийг нь... захидаг сан“, “Өндөр хөх тогорууг... хараадаг гэж үү?“, “Лав үгүй байх аа...үл итгэв“, “Миний бодлыг... зэгзэгнэн айсуй“ гэсэн 5 цогцолбор
8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
   A. Өвөө, төмөр дөрөө, үг, бодол, өндөг, сүүдэр, зүрх, шувуу, үр
   B. Төмөр дөрөө, тогоруу, хайрга, сүүдэр, шувуу, би, хүү, өндөг, үг

C. Хос тогоруу, сайр, үр, өндөг, сүүдэр, хүү, бие, өвөө, үг
D. Тогоруу, би, өндөг, үр, сүүдэр, өвөө, төмөр дөрөө, үг, бодол
E. Хүн, нялх үр, бодол, дөрөөний сэнж, шувуу, дэлхий, өр зүрх, үг, би

9. Дараах өгүүлбэрээс шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
“Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан”
A.Тойруулал B. Төлөөлөл C. Ихэсгэл
D. Адилтгал E. Зүйрлэл

10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Бодит ба хийсвэр зүйлээс үүдэн зохиол бичих болсон шалтгаан, сэдэц санааг.......................................гэнэ.
A. Зорьсон санаа B. Төрсөн санаа C. Гол санаа
D. Шинэ санаа E. Төгс санаа

11. Бүгд өгүүлэгчийн баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
A. ...хүргэчих вий, ...захидаг сан, ...хараадаг гэж үү?, ...Лав үгүй байх аа
B. ...Хөөрхий нялх үрийг нь, ...уурлуулж болдоггүй юм, ...цөмлөчих вий, ...зүрх эмзэглэнэ
C. ...батлах шиг, ...амьтан чинь, ...хараах билээ, ...зүрх өвтгөнө
D. ...улам ч, ...үл итгэв, ...их л ойроос, ...зэгзэгнэн айсуй
E. ...Хөөрхий тэр шувуу, ...гэсэн шиг, хүргэчих вий, ...өрөвдөв

12. Дараах үгсийн аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ?
A. Өндөр тогоруу B. Үгүй байх C. Мөнөөх тогоруу
D. Зөөлөн зөөлөн E. Нялх үр

13. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглан, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Дээр дээр, тогорууны өндөг, хайрган дунд, дөрөөний сэнж, уурлуулж болдоггүй, миний бодол, ..................
A. Тэр шувуу B. Төмөр дөрөө C. Өр зүрх
D. Хөх тогоруу E. Гишгэж байгаа

14. “Өвөөгийн хэлсэн үг өр зүрх өвтгөнө” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
A. Харьяаны тодотгол гишүүн B. Шууд тусагдахуун гишүүн
C. Өгүүлэгдэхүүн гишүүн D. Шууд бус тусагдахуун гишүүн
E. Байц гишүүн

15. “Хөөрхий нялх үрийг нь сүүдрээрээ хиртүүлэхүй намайг хараана гэхээс өвөөгийн хэлсэн үг өр зүрх өвтгөнө” гэсэн өгүүлбэрээс гол дэлгэрүүлэгч гишүүнийг олоорой.
A. Сүүдрээрээ B. Намайг C. Өвөөгийн
D. Өр зүрх E. Нялх

16. “Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү?“ гэсэн өгүүлбэрт үл тохирох шинжийг олоорой!
A. Бүтэц B. Асуух C. Дэлгэрэнгүй
D. Хоёр бүрэлдэхүүнт E. Энгийн

17. “Тогоруу бол төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл хараадаг амьтан” гэсэн өгүүлбэрт тохирох тодорхойлолтыг сонгоорой.
A. Байц гишүүн өгүүлбэртэй УНӨ
B. Хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
C. Үйлийн тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
D. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй УНӨ
E. Олон гишүүн өгүүлбэртэй УНӨ

18. “Миний бодлыг батлах шиг мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуй” гэсэн өгүүлбэрийн тонгоргол аль вэ?
A. Миний бодлыг баталж, мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуй.
B. Мөнөөх хоёр тогоруу зэгзэгнэн айсуй.
C. Миний бодлыг батлах шиг мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуй нь ихэд сайхан санагдлаа.
D. Миний бодлыг батлав.
E. Мөнөөх хоёр тогоруу улам ч зөөлөн зөөлөн гишгэсээр зэгзэгнэн айсуй нь миний бодлыг батлах шиг

19. “Өндөр хөх тогорууг өнөөдөр би их л ойроос харав” гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг зөв тодорхойлсныг сонгоорой.
A. Хөх тогорууг харна. B. Өндөр хөх тогорууг би харав. C. Би ойроос харав.
D. Би тогорууг харна. E. Би харна.

20. Дараах зэргэдийг ажиглан, төсөөт зэргэдийг олоорой.
A. Хатуу сэтгэлт эмээс хайр бүү горьд, Бачуу доторт эмээс найр бүү горьд
B. Цадахад цагаан хурганы сүүл хатуу, Өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн
C. Сайн эр урдаа шархтай, Муу эр хойноо шархтай

D. Шилсэн юм шилд гарах, Голсон юм голд орох
E. Хаяанаас халдахыг хаа, Хажуунаас нялзахыг арч

21. "Хөөрхий нялх үрийг нь сүүдрээрээ хиртүүлэхүй намайг хараана" гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маяг юу вэ?
    A. Өндгөнд сүүдрээ тусгахыг хиртүүлэхтэй адилтгасан
    B. Өндгийг хиртэнэ хэмээн хэтрүүлсэн
    C. Хүнийг сүүдрээр нь төлөөлсөн
    D. Өндгөнд сүүдрээ тусгахыг хиртүүлэх хэмээн тойруулсан
    E. Намайг хараана хэмээн хүншүүлсэн

22. "Хөөрхий тэр шувуу хүнийг тийм сүрхий хараадаг гэж үү?" гэсэн өгүүлбэрийн "тийм" гэдэг нь ямар холбоос вэ?
    A. Шинж чанарыг төлөөлсөн холбоос    B. Цагийг төлөөлсөн холбоос
    C. Орныг төлөөлсөн холбоос    D. Юмыг төлөөлсөн холбоос
    E. Үйлийг төлөөлсөн холбоос

23. Эхний хоёр баганыг харгалзуулан гуравдугаар баганын шинжтэй тохируулаарай.

| | | |
|---|---|---|
| 1. Хос | A. Сэнж | I. Нэрийн хамжих холбоо |
| 2. Дөрөөний | B. Гишгэх | II. Нэрийн найрах холбоо |
| 3. Зөөлөн | C. Сэтлэх | III. Үйлийн хамжих холбоо |
| 4. Сэнжийг | D. тогоруу | IV. Үйлийн найрах холбоо |

    A. (3.A.I), (2.C.II), (1.D.III), (4.B.IV)    B. (1.D.I), (2.A.II), (3.B.III), (4.C.IV)
    C. (4.A.II), (2.B.IV), (3.C.III), (1.D.I)    D. (1.D.II), (2.C.I), (3.B.III), (4.A.IV)
    E. (1.D.III), (3.A.II), (2.C.IV), (4.B.I)

24. Дараах үгсийг ажиглан төрөл биш үгийг олоорой.
    A. Өргөлт    B. Өргөл    C. Өргөмж    D. Өргөгч    E. Өргөс

25. "Хиртүүлэхүй" гэсэн үгийг үеэр зөв тасалсныг олоорой.
    A. Хир - түүл - хүй    B. Хирт - үүл - хүй    C. Хир - түү - лэ - хүй
    D. Хирт - үү - лэх - үй    E. Хир - түүлэ - хүй

26. "Хөөрхий нялх үрийг нь сүүдрээрээ **хиртүүлэхүй** намайг хараана" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль нөхцөлөөр солин найруулбал өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?
    A. -тал$^4$    B. -бал$^4$ (вал$^4$)    C. -нгаа$^4$    D. -аад$^4$    E. -саар$^4$

27. Аль үг нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалж байна вэ?
    A. Үнэ татах    B. Солонго татах    C. Бүрээ татах
    D. Шөрмөс татах    E. Олс татах

28. Дараах жагсаалтад үгийн сангийн найруулгын үүргээрээ аль үг нь илүүц байна вэ?
    A. Адсага    B. Нүд    C. Янгиа    D. Сарвуу    E. Сувс

29. "Нэгтгэх" гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олоорой.
    A. Нэг + тгэ + 0 + 0 + х    B. Нэг + т + гэ + 0 + х    C. Нэг + д + гэ + 0 + х
    D. Нэгтгэ + 0 + 0 + х    E. Нэгд + гэ + 0 + х

30. Дараах үгсээс бүгд зөв бичсэн бүлэг үгийг олоорой.
    A. Суврага, уяъя, авьяас, нударга, хагасла
    B. Тарвага, оёё, Сумъяа, шударга, дээвэрлэ
    C. Хуврага, хаяя, Адъяа, хэдрэг, холтосло
    D. Аварга, хаяя, гавьяа, азарга, хавтасла
    E. Хэврэг, уяя, Адьяа, нудрага, гадарла

31. "Өндгийг, сүүдрээ, бодлыг, нутгийн, ноёд" гэсэн үгсийг бүтээврээр задалж үзээд бүтээврийн ямар хувиргал болохыг тодорхойлоорой.
    A. Дэлгэрүүлэх    B. Хураах    C. Салаалах
    D. Тонгоргох    E. Аль нь ч биш

32. "Хүнд муу биеэрээ дэлхийг цөмлөчих вий гэсэн шиг ийм хөнгөн гишгэж байгаа амьтан чинь дөрөөний сэнжийг яаж сэтэртэл хараах билээ гэхээс өвөөгийн үгэнд үл итгэв" гэсэн өгүүлбэрт ерийн, үүсмэл биш, ганц тоот жинхэнэ нэр хэд байна вэ?
    A. 9    B. 8    C. 7    D. 6    E. 5

33. "Дөрөөний сэнж" гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг олоорой.
    A. Бүхлийн хэсгийг заасан утга
    B. Уул юм хэний, юуны эзэмшилд буй утга
    C. Орших байр, орон зай заасан утга
    D. Шинж чанар заасан утга
    E. Тоо ширхэг, хэмжээ заасан утга

34. Дараах өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.

A. B. C. D E.



35. “Хүлэг дээс” гэсэн холбоо үгийн “хүлэг“ гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A. B. C. D. E.



36. “” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



38. “Монголын нууц товчоо” зохиолын нэгдүгээр бүлэгт Есүхэй баатар Мэргидийн Их Чилэдүгээс Өэлүнийг булаан авахад Өэлүн Онон мөрнийг долгилтол, ой шугуйг ганхтал их дуугаар уйлдаг. Энэ үед :

“Тэврэх хайрт эр чинь
Тэртээ даваа давав.
Уйлан санах эр чинь
Улс олныг гэтлэв” хэмээн хэн өгүүлсэн бэ?

A. Есүхэй
B. Нэгүүн тайж
C. Даридай отчигин
D. Хадаан тайж
E. Хутула

39. “Убаши хунтайжийн тууж” зохиолын гол үзэл санаа юу вэ?

A. Ойрдын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
B. Халхын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
C. Ард түмний энх амгалан, эв нэгдлийн хүслэнг илэрхийлсэн
D. Халх, Ойрдын ноёдын эв нэгдлийг бататгах тэмцлийг дэмжсэн
E. Халх, Ойрдын ноёдын хагарлыг дэмжсэн

40. Д.Пүрэвдорж “Хөх даалимбан тэрлэг” найраглалдаа “Эр цэргийн эхнэр гэдэг эмэгтэйн төдий нэрийг хэлдэггүй. Хортон дайсны сум онодоггүй хоёр амины нэгийг хэлдэг юм” хэмээн товойлгон дүрсэлсний учир юу вэ?
   A. Эх орноо хамгаалахад эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг адилхан гэдгийг харуулах
   B. Эр нөхрөө дайнд үдсэн эмэгтэйн үүрэг хариуцлага нэмэгддэг гэдгийг харуулах
   C. Залуу хосын хайрын сэтгэлд дайны учруулсан харамсал, гашуудлыг харуулах
   D. Дайнд явсан эр нөхөртөө дээл хийж байгаа эмэгтэйн байр байдлыг харуулах
   E. Дайнаас амьд эргэж ирсэн эр нөхрөөрөө бахархаж байгаа эмэгтэйг харуулах

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. ХЗ + УЗ | A. Нэг мөчийн үнэ цэнэ |
| 2. ҮС + ХЗ | B. Энэ дуугаа дуулан дуулсаар |
| 3. БЗ + ҮС | C. Олны дунд биеэ барих |
| 4. УЗ + ҮС | D. Тэнгэрийн заадсыг харж байна |
| 5. БЗ + ХЗ | E. Алтан тариа найган ганхана |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Эрхийг сурахаар бэрхийг сур | A. Цочсон нохой цохноос айх |
| 2. Бардам ам, шалдан гуя | B. Нармайгүй ч гэсэн намбатай нь дээр |
| 3. Тэнэг хүн дуугүйдээ сүртэй | C. Арслан шиг архираад зурам шиг зугтах |
| 4. Өөрөө хожгор байж хүний халзныг гайхах | D. Дэрээ элээхээр дэвсээ элээ |
| 5. Айсан хүнд алсын уул хөдөлнө | E. Өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох |

2. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Уран зохиолын найруулга | A. Ясны хатуулаг нь тоосгоноос 30 дахин ба боржин чулуунаас 2,5 дахин их байдаг |
| 2. Албан бичгийн найруулга | B. Би хийсэн ч юмгүй шив дээ. Намар хэдэн хоног тарианд хөөгдөөд |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй |
| 4. Эрдэм шинжилгээний найруулга | D. Өнөөдөр Улаанбаатар хотод +20 хэм дулаан, багавтар үүлтэй байна |
| 5. Ярианы найруулга | E. Тугал тугал тоглоно. Туул голдоо очно |

2.4. Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Очирын шунахай сэтгэл улам хөгжиж хээр мориндоо унасан хүнийг булгиж хаях ба цулбуураа тасдаж уяанаас зугтах зэрэг муу зан сургажээ. | A. С.Эрдэнэ “Хулан бид хоёр” |
| 2. Долдугаар сарын нэгэн өдөр би нутгийнхаа Чингис хаан болоод түүний залуу гэргийн хамт сумынхаа наадамд очихоор эртлэн мордлоо. Тэр Чингис хаан гэдэг маань ердөө л шар Цамба юм шүү дээ. | B. П.Пүрэвсүрэн “Өшөө |
| 3. Манаач өвгөн орой манаанд гарах бүр үнэртэй усны нэг бяцхан хавтгай дугуй шилэнд архи хийж өвөртлөөд, өвөл бол дах, зун бол цуваа хэдрээд, муу бярдаан буугаа барин дэлгүүрийн үүдэнд байдаг модон вандан сандал дээр суугаад... | C. Ц.Дамдинсүрэн “Өлзийтийн хээр” |
| 4. Уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан хүүхэн Иүй Бай-Хуа... | D. Б.Ринчен “Мангаа Доогийн эцсийн зүүд” |
| 5. Дорж хойд Шээзгийт дээр дурандаж суутал Дорги чоноо хөтөлсөөр Шээзгийтийн шандан дээр ирэх нь харагджээ. | E. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” |

## ХУВИЛБАР В

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Нутгийн айраг

Ах маань энэ жил бас л ирж над нэг хөхүүр айраг авчрав. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана.

Цээлийн нууранд олон адуу шаагин ороход Хангайн булагаас зорьж ирээд амарч амжаагүй лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин нисч, адуун дээгүүр хэдэнтээ өнгөрөхүй усны захад хулган зогссон хэнз халтар унага тэдний сүүдрээс цочин давхийж, түүнийгээ булзааруулахын тулд эргийн ногоон зүлгэн дээгүүр тонгочин давхина.

Аагаа багтааж ядсан тарган байдаснууд нуурын гол руу их л лав ороход адууны зах барьдаг асман зээрд хойноос нь очмоор санагдавч хээр азарганаас баахан эмээнэ. Тэгээд хялалзан, “энэ муу хөгшин хээр норсон дэлээ даахгүй“ гэж сэм бодовч ноднин жилийн хасуулсан хөндүүр гараагүй тул албаар ус цавчлан бодлоо сарниулж нүглийг умартана.

Олон адуу уснаас шаагин гарч саамын зэл рүү цувахад сагагнаас нь ус дуслан онгож байгаа өвсөнд адууны мөрөөр шүүдэр үлдэнэ.

Сэлэнгийн шар намар, замын тоос, ажлын цуурай тэнгэрт хадаж ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина. (*Ж. Лхагва*)

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг дугуйлаарай.
   1. Асман зээрд хээр азарганаас баахан эмээнэ.
   2. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана.
   3. Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг адуу шиг шаагина.
   4. Олон адуу уснаас шаагин гарна.
   5. Цээлийн нууранд олон адуу шаагин орно.

   A. 2, 5, 1, 4, 3 B. 2, 5, 3, 1, 4 C. 2, 5, 4, 3, 1
   D. 2, 5, 1, 3, E. 2, 5, 4, 1, 3
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?
   A. Хүний зүйл B. Ургамлын зүйл C. Хий үзэгдлийн зүйл
   D. Сэтгэхүйн зүйл E. Хүний бүтээсэн зүйл
3. Дээрх эхийн хэв маяийг тодорхойлно уу.
   A. Тоочимж B. Эргэцүүлэмж C. Тайлбарламж
   D. Учирламж E. Хүүрнэмж
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?
   A. Уран зохиолын найруулга B. Албан бичгийн найруулга C. Сонин нийтлэлийн найруулга
   D. Ярианы найруулга E. Эрдэм шинжилгээний найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.
   A. Нуур, усны тухай B. Аав, ээжийн тухай C. Айрагны тухай
   D. Адууны тухай E. Ажил, хөдөлмөрийн тухай
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Хэнз халтар унага эргийн ногоон зүлгэн дээгүүр тонгочин давхина.
   B. Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина.
   C. Нууранд адуу шаагин ороход лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин ниснэ.
   D. Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана.
   E. Асман зээрд байдаснуудын хойноос нь очмоор санагдавч хээр азарганаас баахан эмээнэ.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
   A. “Ах маань... ирсэн мэт санагдана“, “Цээлийн нууранд... нүглийг умартана“, “Олон адуу... шүүдэр үлдэнэ“, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина“ гэсэн 4 цогцолбор
   B. “Ах маань...шүүдэр үлдэнэ“, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина“ гэсэн 2 цогцолбор
   C. “Ах маань... ирсэн мэт санагдана. “, “Цээлийн нууранд... шүүдэр үлдэнэ. “, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шаагина. “ гэсэн 3 цогцолбор
   D. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
   E. “Ах маань... ирсэн мэт санагдана“, “Цээлийн нууранд... тонгочин давхина“, “Аагаа багтааж ядсан... нүглийг умартана“, “Олон адуу...шүүдэр үлдэнэ“, “Сэлэнгийн шар намар... адуу шиг шуугина“ гэсэн 5 цогцолбор

8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
   A. Хөхүүр, айраг, лам шувуу, хэнз унага, адуу, шүүдэр
   B. Ах, хөхүүр, айраг, нуур, адуу, ус
   C. Ах, ээж, аав, айраг, адуу, ажил
   D. Хөхүүр айраг, Цээлийн нуур, Хангайн булаг, хөндүүр, бодол
   E. Халтар унага, байдас, асман зээрд, хөгшин хээр, хөхүүртэй айраг
9. Дараах өгүүлбэрээс шинэ санааг илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
   "Ахын авчирч өгсөн хөхүүртэй айраг усанд орж байгаа адуу шиг шаагина"
   A. Зүйрлэл B. Төлөөлөл C. Ихэсгэл
   D. Адилтгал E. Тойруулал
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
   Хэлний дүрслэх хэрэглүүрээр оновчтой, уран, шинэ дүр дүрслэл, содон санаа бүтээхийг эхийн.........гэнэ.
   A. Зорьсон санаа B. Төрсөн санаа C. Гол санаа
   D. Шинэ санаа E. Төгс санаа
11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
   A. ...ирсэн мэт, ...энэ муу, ...харамлах мэт, ...бас л ирж, ... их л лав, ...адуу шиг шаагина
   B. ...цочин давхийж, ...очмоор санагдавч, ... их л лав, ...энэ муу, ...баахан эмээнэ
   C. ...харамлах мэт, ...бас л ирж, ...ирсэн мэт, ... сэм бодовч, ...энэ муу, ...орь дуу тавих
   D. ...ирсэн мэт, ... сэм бодовч, ...орь дуу тавих, ... их л лав, ...энэ муу, ... тонгочин давхина
   E. ...очмоор санагдавч, ... сэм бодовч, ... орь дуу тавих, ...энэ муу, ...адуу шиг шаагина
12. Дараах үгсийн аль нь хэлзүйжсэн холбоо үг вэ?
   A. Хөхүүр айраг B. Нуурын зах C. Хангайн булаг
   D. Лам шувуу E. Ноднин жил
13. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглан, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
   Адуун дээгүүр, замын тоос, усны захад, хөхүүртэй айраг, гараагүй тул, саамын зэл, .............
   A. Халтар унага B. Ноднин жил C. Шар намар
   D. Авчирч өгсөн E. Хөгшин хээр
14. "**Ээжийн** явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана" гэсэн өгүүлбэрийн онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
   A. Харьяаны тодотгол гишүүн B. Байц гишүүн
   C. Шууд тусагдахуун гишүүн D. Өгүүлэгдэхүүн гишүүн
   E. Шууд бус тусагдахуун гишүүн
15. "Лам шувуунууд адуун дээгүүр хэдэнтээ өнгөрөхүй усны захад хулган зогссон хэнз халтар унага сүүдрээс нь цочин давхийнэ" гэсэн өгүүлбэрээс гол дэлгэрүүлэгч гишүүнийг олоорой.
   A. Сүүдрээс B. Адуун дээгүүр C. Усны захад
   D. Унага E. Хэдэнтээ
16. "Ах маань энэ жил над нэг хөхүүр айраг авчрав" гэсэн өгүүлбэрт үл тохирох шинжийг олоорой.
   A. Бүтэц B. Дэлгэрэнгүй C. Хүүрнэх
   D. Энгийн E. Хоёр бүрэлдэхүүнт
17. "Лам шувуунууд адуун дээгүүр хэдэнтээ өнгөрөхүй хэнз халтар унага тэдний сүүдрээс цочив" гэсэн өгүүлбэрт тохирох тодорхойлолтыг сонгоорой.
   A. Байц гишүүн өгүүлбэртэй УНӨ B. Хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
   C. Үйлийн тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ D. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй УНӨ
   E. Олон гишүүн өгүүлбэртэй УНӨ
18. "Цээлийн нууранд олон адуу шаагин ороход лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин ниснэ" гэсэн өгүүлбэрийн тонгоргол аль вэ?
   A. Цээлийн нууранд олон адуу шаагин орно.
   B. Лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин ниснэ.
   C. Цээлийн нууранд олон адуу шаагин ороход лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин нисэх нь ах бид хоёрын анхаарлыг татав.
   D. Лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин нисэх нь Цээлийн нууранд олон адуу шаагин орсных.
   E. Цээлийн нууранд олон адуу шаагин ороход лам шувуунууд усаа харамлах мэт орь дуу тавин ниссэн үү?
19. "Хэнз халтар унага эргийн ногоон зүлгэн дээгүүр давхина" гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг зөв тодорхойлсныг сонгоорой.
   A. Хэнз халтар унага давхина B. Унага зүлгэн дээгүүр давхина C. Унага давхина
   D. Халтар унага давхина E. Хэнз унага давхина

20. Дараах зэргэдийг ажиглан, ойролцоо зэргэдийг олоорой.
    A. Харахад царайгүй харчгар, Үзэхэд үзэмжгүй үрчгэр
    B. Зүтгэвэл зүйлийг олно, Зогсвол залхууг олно
    C. Атгахад атга дүүрэхгүй, Тавихад тал дүүрнэ
    D. Хортон гартаа устай, Ачтан гартаа тостой
    E. Хаан хүний хүү хар торгон дээлтэй, Ноён хүний хүү ногоон торгон дээлтэй
21. "Ээжийн явуулсан хөхүүрэнд аавын адуу багтаад ирсэн мэт санагдана" гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маяг юу вэ?
    A. Адууг хөхүүрэнд багтсан мэтээр багасгаж, айрагны шуугих чимээг адууны шаагихтай адилтгасан
    B. Нутгаа санасан сэтгэлийг илэрхийлсэн тойруулал
    C. Өссөн, төрсөн нутгаа адуугаар төлөөлүүлж, айрагны шуугих чимээг адууны шаагихтай зүйрлэсэн
    D. Айрагны шуугин исэх чимээг адуутай адилтгасан
    E. Адууг хөхүүрэнд багтаасан мэтээр дүрсэлсэн багасгасан хэтрүүлэл
22. "Хэнз халтар унага лам шувуунуудын сүүдрээс цочин давхийж, түүнийгээ булзааруулахын тулд эргийн ногоон зүлгэн дээгүүр тонгочин давхина" гэсэн өгүүлбэрийн "түүнийгээ" гэдэг нь ямар холбоос вэ?
    A. Шинж чанарыг төлөөлсөн холбоос　　B. Цагийг төлөөлсөн холбоос
    C. Орныг төлөөлсөн холбоос　　D. Юмыг төлөөлсөн холбоос
    E. Үйлийг төлөөлсөн холбоос
23. Эхний хоёр баганыг харгалзуулан гуравдугаар баганын шинжтэй тохируулаарай.

| | | |
|---|---|---|
| 1. Хөхүүр | A. Багтах | I. Нэрийн хамжих холбоо |
| 2. Аавын | B. Адуу | II. Нэрийн найрах холбоо |
| 3. Хөхүүрэнд | C. Айраг | III. Үйлийн хамжих холбоо |
| 4. Сэм | D. Бодох | IV. Үйлийн найрах холбоо |

    A. (3.A.I), (2.D.II), (1.C.III), (4.B.IV)　　B. (1.C.I), (2.A.II), (3.B.III), (4.D.IV)
    C. (4.A.II), (2.D.IV), (3.B.III), (1.C.I)　　D. (1.C.I), (2.B.II), (3.A.IV), (4.D.III)
    E. (1.C.III), (3.D.II), (2.A.IV), (4.B.I)
24. Дараах үгсийг ажиглан төрөл биш үгийг олоорой.
    A. Эвт　B. Эвлэл　C. Эвэр　D. Эвсэл　E. Эвцэл
25. "Өнгөрөхүй" гэсэн үгийг үеэр зөв тасалсныг олоорой.
    A. Өн - гө - рө - хүй　B. Өнгөр - хүй　C. Өн - гөр - хүй
    D. Өнгө - рө - хүй　E. Өн - гөр - өх - үй
26. "Лам шувууд адуун дээгүүр хэдэнтээ **өнгөрөхүй**, усны захад хулган зогссон хэнз халтар унага тэдний сүүдрээс цочин давхийв" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль нөхцөлөөр солин найруулбал өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?
    A. -д　B. -хаар$^4$ (-хлаар$^4$)　C. -нгаа$^4$
    D. -аад$^4$　E. -саар$^4$
27. Аль үг нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалж байна вэ?
    A. Тураг мах　B. Махан төмөр　C. Яс махны тасархай
    D. Махан орчуулга　E. Махан толгой
28. Дараах жагсаалтад үйн сангийн найруулгын үүргээр аль үг илүүц вэ?
    A. Сархад　B. Эрвээлж　C. Хатагтай　D. Мутар　E. Адуу
29. "Эзэмшүүлэх" гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олоорой.
    A. Эз + мш + үүл + 0 + х　B. Эзэн + ш + үүл + 0 + х　C. Эзэн + мш + үүл + 0 + х
    D. Эзэмш + үүл + 0 + х　E. Эзэм + ш + үүл + 0 + х
30. Дараах үгсээс бүгд зөв бичсэн бүлэг үгийг олоорой.
    A. Эрхтний, газарчилъя, хооллолоо, хувиргасныг, багшид
    B. Шархтны, товчилъё, ажиллаа, ариутгасныг, тогоочод
    C. Өвчтөний, жолоодоё, тослолоо, тавагласныг, эмчид
    D. Төрөлхтний, хайчилъя, өнгөллөө, үзэснийг, донжийг
    E. Торхчны, царайчилъя, эмхэллээ, олсныг, баншыг
31. "Өвөөгийн, хөхүүрэнд, захад, азарганаас, сагагнаас" гэсэн үгсийг бүтээврээр задалж үзээд бүтээврийн ямар хувиргал болохыг тодорхойлоорой.
    A. Тонгоргох　B. Хураах　C. Салаалах
    D. Дэлгэрүүлэх　E. Аль нь ч биш
32. "Аагаа багтааж ядсан тарган байдаснууд нуурын гол руу их л лав ороход асман зээрд үрээ хойноос нь очмоор санагдавч хээр азарганаас баахан эмээнэ" гэсэн өгүүлбэрт ерийн, үүсмэл биш, ганц тоот жинхэнэ нэр хэд байна вэ?
    A. 6　B. 5　C. 4　E. 3　E. 2

33. “Ноднин жилийн хөндүүр” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг олоорой.
    A. Бүхлийн хэсгийг заасан утга
    B. Уул юм хэний, юуны эзэмшилд буй утга
    C. Цаг хугацааны утга
    D. Шинж чанар заасан утга
    E. Тоо ширхэг, хэмжээ заасан утга
34. Дараах өгүүлбэрийг уншаад, аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.
    A. B. C. D. E.



35. “Санхүү” гэсэн холбоо үгийн “хүү” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.
    A. B. C. D. E.



36. “Erdeni” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.
    A. B. C. D. E.



37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.
    A. B. C. D. E.



38. “Монголын нууц товчоо” зохиолын нэгдүгээр бүлэгт Есүхэй баатар Татарт хорлогдон арай ядан гэрт хүрч “Миний дотор муу байна… Тэмүүжин хөвгүүнийг даруй авчир” гэхэд дэргэд нь хэн байсан бэ?
    A. Чирха B. Бэлгүтэй C. Даридай отчигин D. Дэй Сэцэн E. Мэнлиг
39. “Хув Нагваралын тууж” зохиолын гол үзэл санаа юу вэ?
    A. Ард түмний энх амгалан, эв нэгдлийн хүслэнг илэрхийлсэн
    B. Халх, Ойрдын ноёдын хагарлыг дэмжсэн
    C. Ойрдын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн
    D. Халх, Ойрдын ноёдын эв нэгдлийг бататгах тэмцлийг дэмжсэн
    E. Халхын ноёдын харгис хэрцгий, дайнч байдлыг шүүмжилсэн

40. Ц. Дамдинсүрэн гуай “Чемодантай юм” өгүүллэгтээ Цээмаа, Бумаа хоёрын уулзан ярилцаж байгаа хэсэгт нэгэн хогийн савны тухай дүрсэлсэн байдаг. Энэ нь юуг харуулсан хэрэг вэ?
    A. Тэдний уулзаж байгаа газрын бохир байдлыг
    B. Хүний гадаад байдал, дотоод сэтгэл хоёрын ялгааг
    C. Нар жаргаж байгааг тод томруун харуулахын тулд
    D. Цээмаагийн шуналтай занг хогийн савтай зүйрлэхийн тулд
    E. Тэр хоёрт ярианы сэдэв гаргахын тулд

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. ҮС + БЗ | A. Ам алдвал барьж болдоггүй |
| 2. ҮС + ХЗ | B. Манан хүдэнт уулсын орой |
| 3. БЗ + ҮС | C. Нам гүмхэн нэгэн үдэш |
| 4. УЗ + ХЗ | D. Нэг гэрт толгой холбох |
| 5. БЗ + УЗ | E. Төв аймгийн засаг дарга |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Өлөн гэдэс өвчүүтэй наалдах | A. Сүүнд халсан хүн тараг үлээх |
| 2. Үнээ үхэхдээ сүү оров. | B. Дотор газраас өр нэхэх |
| 3. Хэрээ хэрээнийхээ харыг гайхав | C. Гар бариад бугүй барих |
| 4. Сандрахдаа сар өөд самардах | D. Ниргэсэн хойно нь хашхирах |
| 5. Амташсан хэрээ арван гурав эргэх | E. Эргүү шулга хоёр бие биеэ хэлэв гэх шиг |

2.3 Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Уран зохиолын найруулга | A. Монгол Улсын Ерөнхий сайд хуулийн төсөл өргөн барилаа. |
| 2. Албан бичгийн найруулга | B. Монгол таргийн хөрөнгийн микрофлор, амт, чанар Болгар таргтай ихээхэн ойролцоо байна. |
| 3. Сонин нийтлэлийн найруулга | C. Мужаан З.Доржийн ажилласан хоногийн хөлсийг тооцон олгохыг ня-бо Ж.Алтанд зөвшөөрсүгэй. |
| 4. Эрдэм шинжилгээний найруулга | D. Ажил нь жаахан хэцүү юм аа. За уулзана аа хоёулаа. |
| 5. Ярианы найруулга | E. Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. |

2.4. Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Зуны цагт баруун баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, үнэр ханхлах нь үнэхээр таван багц хүжийг шатаавч үл дарагдмаар. | A. С.Эрдэнэ “Малын хөлийн тоос” |
| 2. “Хун галуу, нагал хавч, хурын үүл, хурмастын хишиг, ясны хайртай Янжин, янагийн хайртай Чанцал. Татлаа, татуулах уу” | B. П.Пүрэвсүрэн “Өшөө” |
| 3. Их мөрний хөвөөнд үнэт эрдэнэ гээчээд эрж яваа юм шиг урагш хойш тонголзон холхих нэгэн хүний хэлбэр төрхийг алсаас харахад нар шингэх үеийн хайлаас модны сүүдэр шиг тахир агаад нэн өндөр. | C. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” |
| 4. Энэ үед Дорж гуайг харахад их үер юм уу, салхинд хэсэг мөчрөө хугалуулсан боловч ялж гараад навч дэлгэн байгаа бүдүүн улиас шиг байв. | D. Д.Мягмар “Үер” |
| 5. Энэ хойд хадат ааргийг дээр үед Шээзгий толгод гэдэг байсан юм. Нээрэн ч холоос харахад чандмалан хөмөрсөн гурван шээзгий шиг харагддаг юм л даа. | E. Ч.Лодойдамба “Хугараагүй ноён нуруу” |

## ХУВИЛБАР C

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Шаргачин

Буу зогсолтгүй шахам нижгэнэж, машины дохио чимээ үргэлжлэн дуугарч, шаргачны үсрэх цойлох нь ховордон, цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа.

Машин дотроос “Хар барам чинь оногдохгүй нь. Ёо, ёо, ямар их донсолдог юм бэ? Толгой хагалчих нь. Аль вэ сум аваад аль! Өмнө нь барьж байгаад мулталж орхи. Аа, мондиос чинь болж гараа шалбалж орхилоо. Чамайг уу даа!” гэх зэрэг дуу сонстож байлаа.

Гагцхүү жолоочийн ард хөдлөлгүй суугаад хөмхийгөө зуун, салхинд бага зэрэг гандсан нүүрээ барайлган, барьж ядсан заналхийлэл нүдэнд нь туяарсан нэг хүн үг дуугаралгүй “Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна.“ гэж сэтгэлдээ дахин дахин шивэгнэн явжээ.

Үнэндээ, хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ. *(Ч.Лодойдамба)*

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой.
   1. Аа, мондиос чинь болж гараа шалбалж орхилоо.
   2. Хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ.
   3. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна.
   4. Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш.
   5. Шаргачны үсрэх цойлох нь ховордон...

   A. 5, 1, 3, 4, 2 B. 5, 1, 4, 2, 3 C. 5, 4, 1, 3, 2
   D. 5, 2, 4, 3, 1 E. 5, 1, 4, 3, 2
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?
   A. Хүний зүйл B. Амьтны зүйл C. Гариг эрхсийн зүйл
   D. Ургамлын зүйл E. Хүний бүтээсэн зүйл
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу.
   A. Хүүрнэмж B. Тоочимж C. Эргэцүүлэмж
   D. Тайлбарламж E. Учирламж
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?
   A. Албан бичгийн найруулга B. Эрдэм шинжилгээний найруулга
   C. Уран зохиолын найруулга D. Сонин нийтлэлийн найруулга
   E. Ярианы найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.
   A. Шаргачны тухай B. Харгис зангийн тухай
   C. Амьдралын тэмцлийн тухай D. Байгаль хамгааллын тухай
   E. Хүн, байгалийн хүйн холбоо
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Шаргачны үсрэх цойлох нь ховордон, цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа.
   B. Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш.
   C. Гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна.
   D. Шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ.
   E. Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ?
   A. “Буу... бууж байлаа”, “Машин дотроос... сонстож байлаа”, “Гагцхүү...дуугаралгүй”, “Толгойгоо цохих... шивэгнэн явжээ”, “Үнэндээ... тэмцэл байжээ” гэсэн 5 цогцолбор
   B. “Буу... бууж байлаа”, “Машин дотроос... сонстож байлаа”, “Гагцхүү... шивэгнэн явжээ”, “Үнэндээ... тэмцэл байжээ” гэсэн 4 цогцолбор
   C. “Буу... сонстож байлаа”, “Гагцхүү... шивэгнэн явжээ”, “Үнэндээ... тэмцэл байжээ” гэсэн 3 цогцолбор
   D. “Буу... сонстож байлаа”, “Гагцхүү... тэмцэл байжээ” гэсэн 2 цогцолбор
   E. 1 цогцолбороос бүтсэн бичил эх

8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
   A. Шаргачин, буу, машин, толгой, гар, тэмцэл, нэг хүн, дуу
   B. Шаргачин, дохио чимээ, буу, дуу, машин, монди, тэмцэл, нүд
   C. Шаргачин, хөөгчид, жолооч, буу, дуу, машин, тэмцэл, нүд
   D. Шаргачин, буу, дуу, толгой, гар, хууль, тэмцэл, чих
   E. Шаргачин, чих, нүд, хөмхий, нүүр, дуу, тэмцэл, хууль
9. Дараах өгүүлбэрээс шинэ санаа илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
   “Үнэндээ, хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ”
   A. Адилтгал B. Ихэсгэл C. Төлөөлөл
   D. Тойруулал E. Хүншүүлэл
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
   Зохиолын төрсөн санааг гол үйл явдлаар дүрсэлж, дүгнэлт гаргахыг эхийн..........................................гэнэ.
   A. Төрсөн санаа B. Гол санаа C. Зорьсон санаа D. Шинэ санаа E. Төгс санаа
11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
   A. ... Хар барам чинь, ... зогсолтгүй шахам, ... мулталж орхи, ... хөгжилтэй тохиол
   B. ... Мондиос чинь болж, ... оногдохгүй нь, ... цэлмэг нүд, ... бууж байлаа
   C. ... Эрхлэх чинь л, ... дахин дахин, ... ямар их, ...толгойгоо цохих
   D. ...Үнэндээ, ... ёо, ёо, ... аваад аль!, ...шивэгнэн явжээ
   E. ... Ямар их донсолдог юм бэ?, ... чамайг уу даа!, ... шалбалах чинь юу ч биш, ... үнэндээ
12. Дараах үгсийн аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ?
   A. Машин дотроос B. Энэ явдал C. Мулталж орхи
   D. Үсрэх цойлох E. Толгойгоо цохих
13. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглан, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
   Зогсолтгүй шахам, машины дохио, шалбалж орхилоо, босоо чих, дахин дахин, хөгжилтэй тохиол, ..........
   A. Нэг хүн B. Гараа шалбалах C. Тоглон эрхлэх
   D. Жолоочийн ард E. Энэ явдал
14. “Шаргачны үсрэх цойлох нь ховордоно” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
   A. Харьяаны тодотгол гишүүн B. Шууд тусагдахуун гишүүн
   C. Шууд бус тусагдахуун гишүүн D. Үйлийн тодотгол гишүүн
   E. Өгүүлэгдэхүүн гишүүн
15. “Буу зогсолтгүй шахам нижгэнэж, машины дохио чимээ үргэлжлэн дуугарч, шаргачны үсрэх цойлох нь ховордоно” гэсэн өгүүлбэрээс гол дэлгэрүүлэгч гишүүнийг олоорой.
   A. Шаргачны B. Буу C. Дохио D. Машины E. Чимээ
16. “Хүмүүс гэмгүй амьтны амьдралаар тогложээ” гэсэн өгүүлбэрт үл тохирох шинжийг олоорой.
   A. Бүтэц B. Хүүрнэх C. Энгийн
   D. Гурван бүрэлдэхүүнт E. Дэлгэрэнгүй
17. “Шаргачны үсрэх цойлох нь ховордоно” гэсэн өгүүлбэрт тохирох тодорхойлолтыг сонгоорой.
   A. Хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ B. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
   C. Үйлийн тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ D. Байц гишүүн өгүүлбэртэй УНӨ
   E. Олон гишүүн өгүүлбэртэй УНӨ
18. “Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байжээ” гэсэн өгүүлбэрийн тонгоргол аль вэ?
   A. Шаргачин хоёр амийн төлөө ширүүн тэмцэл хийсэн.
   B. Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан.
   C. Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байсан юм шүү!
   D. Хөөгчдөд энэ явдал богино хугацааны хөгжилтэй тохиол байсан бол шаргачинд хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл байсан нь харамсалтай.
   E. Шаргачны, хоёр амийн төлөө хийж байгаа ширүүн тэмцэл нь хөөгчдөд богино хугацааны хөгжилтэй тохиол байсан.
19. “Босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа” гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг зөв тодорхойлсныг олоорой.
   A. Босоо чих нь бууж байлаа. B. Чих нь алгуураар бууж байлаа.
   C. Босоо чих нь хойшоо бууна. D. Чих нь бууна.
   E. Чих нь хойшоо бууна.
20. Дараах зэргэдийг ажиглан, төсөөт зэргэдийг олоорой.
   A. Хорлох нэгнийг үгнээс нь, Ачлах нөхрийг ажлаас нь
   B. Биеэ мэдвэл хүн, Бэлчээрээ мэдвэл мал

C. Даага эхдээ ялдам, Дархан дөшиндөө ялдам
D. Цэцэнд хоёр чих цөөндөх, Тэнэгт ганц хэл олдох
E. Усан далай булгаас эхтэй, Ухаан далай номоос эхтэй

21. “Гэвч энэ удаа түүний хойноос будаан сумаар зэвсэглээд гүйцэгдэхгүй зовоон зугтааж байгаа зээрийг юу болсон ч алах ангийн шунал оргилсон дайсан мөрдөж яваа” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маяг юу вэ?
   A. Зээр суманд гүйцэгдэхгүй гэж хэтрүүлсэн
   B. Олноор гарч буй сумыг будаатай адилтгасан
   C. Анчдыг дайсан гэж орлуулсан
   D. Шунал оргилно гэж бэлгэдсэн
   E. Зээрийг гүйцэхгүй зовж байгаа мэтээр егөөдсөн
22. “Толгойгоо цохих, гараа шалбалах чинь юу ч биш. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь дэндэж байна” гэсэн өгүүлбэрийн “харин” гэдэг холбоос ямар холбоос вэ?
   A. Шалтгааны утгатай гадаад холбоос
   B. Зорилгын утгатай гадаад холбоос
   C. Болзох утгатай гадаад холбоос
   D. Эсрэгцэх утгатай гадаад холбоос
   E. Ялгах утгатай гадаад холбоос
23. Эхний хоёр баганыг харгалзуулан гуравдугаар баганын шинжтэй тохируулаарай.

| | | |
|---|---|---|
| 1. Хөмхийгөө | A. Хугацаа | I. Үйлийн найрах холбоо |
| 2. Богино | B. Дохио | II. Нэрийн хамжих холбоо |
| 3. Их | C. Зуух | III. Үйлийн хамжих холбоо |
| 4. Машины | D. Донслох | IV. Нэрийн найрах холбоо |

   A. (1.A.I), (3.D.III), (4.B.IV), (2.C.II)
   B. ( 2.A.II), (3.B.III), (1.C.I), (4.D.IV)
   C. (3.D.III), (1.C.I), (2.A.II), (4.B.IV)
   D. (4.D.I), (2.B.II), (1.C.III), (3.A.IV)
   E. (1.D.I), (3.B.IV), (2.C.II), (4.A.III)
24. Дараах үгсийг ажиглан төрөл биш үгийг олоорой.
   A. Бодрол B. Бодолт C. Бодис D. Бодол E. Бодлого
25. “Дуугаралгүй” гэсэн үгийг үеэр зөв тасалсныг олоорой.
   A. Дуу - гар - лгүй B. Дуу - гар - алгүй C. Дуу - га - ралгүй
   D. Дуу - га - рал - гүй E. Дуу - га - ра - лгүй
26. “Толгойгоо **цохих**, гараа шалбалах чинь юу ч биш” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль нөхцөлөөр солин найруулбал өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?
   A. -нгаа[4] B. -ж C. -нгуут[2] D. -вал[4] E. -магц[4]
27. Аль үг нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалж байна вэ?
   A. Дугараа барих B. Холбоо барих C. Нэр барих
   D. Сэтгэлээ барих E. Гэр барих
28. Дараах жагсаалтад үгийн сангийн найруулгын үүргээр аль үг нь илүүц байна вэ?
   A. Таван хялгас B. Сүг C. Овоохой D. Бөндгөр E. Үс
29. “Султгах“ гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олоорой.
   A. Сул + тга + 0 + 0 + х B. Сул + т + га + 0 +х C. Сул + д + га + 0 + х
   D. Султга + 0 + 0 + х E. Сулд + га + 0 + х
30. Дараах үгсээс бүгд зөв бичсэн бүлэг үгийг олоорой.
   A. Унагаллаа, уншсаныг, халих, бодъё, тасла
   B. Ишгэллээ, бодсоныг, урилга, саная, хазла
   C. Тугаллалаа, бичсэнийг, солбих, тэгье, талла
   D. Ботголлоо, явсныг, ханьсах, идэе, тасал
   E. Хургаллаа, идэснийг, хавирах, уншъя, тагла
31. “Нүдэнд, салхинд, ховордон, манантаж, дэндэж” гэсэн үгсийг бүтээврээр задалж үзээд бүтээврийн ямар хувиргал болохыг тодорхойлоорой.
   A. Хураах B. Дэлгэрүүлэх C. Салаалах
   D. Тонгоргох E. Аль нь ч биш
32. “Машины дохио чимээ үргэлжлэн дуугарч, шаргачны цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа” гэсэн өгүүлбэрт эс тусах, үүсмэл үйл үг хэд байна вэ?
   A. 3 B. 4 C. 5 D. 6 E. 7
33. “Жолоочийн ард” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг олоорой.
   A. Бүхлийн хэсгийг заасан утга
   B. Уул юм хэний, юуны эзэмшилд буй утга
   C. Шинж чанар заасан утга
   D. Тоо ширхэг, хэмжээ заасан утга
   E. Орших байр, орон зай заасан утга

34. Дараах өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.

A. B. C. D. E.



35. “Өр шир” гэсэн холбоо үгийн “өр” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A. B. C. D. E.



36. “” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



38. “Монголын нууц товчоо” зохиолын хоёрдугаар бүлэгт Өэлүн үжин ихсийн газар тайлгын идээ өргөхөд хоцорч ирдэг бөгөөд энэ үед
“Урьж чамд өгөх ёсгүй
Учирвал чи идэх ёстой!
Хүргэж чамд өгөх ёсгүй
Хүртвэл чи идэх ёстой!” гэж хэн хэлдэг вэ?
   A. Таргудай
   B. Тодойн Гиртэ
   C. Чирха өвгөн
   D. Орбай Сохатай хоёр
   E. Сочигэл

39. “Мандухай цэцэн хатны домог”-ийн гол үзэл санаа юу вэ?
   A. Эмэгтэйчүүд нь эрчүүдээс дутахгүй төр улсыг удирдан жолооддог гэдгийг харуулсан
   B. Феодалын бутралыг зогсоож, төр улсаа тогтоон барьж, нэгдэх үйл явцыг дэмжсэн
   C. Эмэгтэй хүний хүнлэг, тусч, сайхан чанарыг харуулсан
   D. Феодалын бутралаас болж ард түмний амьдрал хүнд хэцүү болж байгааг шүүмжилсэн
   E. Өвөг дээдэстээ үнэнч байхыг харуулсан

40. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” өгүүллэгт “гэвш Лодонг улаан шарыг тунуулсаар, Цэрэнлхамыг цагаан харыг гялбалзуулсаар” гэж дүрсэлсний учир юу вэ?
   A. Лодонг лам хүн гэдгийг тодруулах зорилгоор дүрсэлсэн
   B. Цэрэнлхамыг ганган эмэгтэй гэдгийг харуулах зорилгоор дүрсэлсэн
   C. Хүний сэтгэлийн дотоод илрэлийг гадаад өнгө үзэмжтэй нь нийцүүлэн дүрсэлсэн
   D. Лодонг лам, Цэрэнлхамыг ганган эмэгтэй хүн гэдгийг харуулахын тулд ингэж дүрсэлсэн
   E. Тэр хоёрын өмссөн хувцас эрс тэс ялгаатайг харуулахын тулд ингэж дүрсэлсэн

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. ҮС + ХЗ | A. Орон орноос ирсэн байна |
| 2. УЗ + БЗ | B. Голоо тасартал гомдох боллоо |
| 3. ХЗ + ХЗ | C. Үржил шимт газар шороо |
| 4. УЗ + ХЗ | D. Эх орны ирээдүйн төлөө |
| 5. ҮС + ҮС | E. Хүйтэн харцтай нэгэн хүн |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Шоодох хүний шазуур үмхий | A. Хийморийг нь тугал зажилсан |
| 2. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги дээр | B. Мянган өдөр сүүдэр болохоор нэг өдөр хүн яв |
| 3. Ухаанд нь ухна ишиг үхсэн | C. Буруу ишилсэн сүх шиг |
| 4. Барын сүүл болохоор батганын толгой бол | D. Амласнаас атганд буй нь дээр |
| 5. Ямаа гэхээр тэмээ гэх | E. Санаа муут шавар дотортой |

2.3. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Албан бичгийн найруулга | A. 5 дугаар зүйл. Монгол улсын төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. |
| 2. Сонин нийтлэлийн найруулга | B. Я.Цэвэл “ Монгол хэлний товч тайлбар тольд “Аванхай“ гэдэг үгийг “уршиг, нөлөө” гэж тайлбарлажээ. |
| 3. Уран зохиолын найруулга | C. За ганц сайн үзчих үү? |
| 4. Ярианы найруулга | D. - Та манай оронд дахиад хэзээ ирэх вэ?<br>- Манай хоёр орны харилцаа улам бэхжиж байгаа болохоор дахин ирнэ гэдэгт бат итгэж байна. |
| 5. Эрдэм шинжилгээний найруулга | E. Усан булаг дэлгэрвэл<br>Уужим дэлхий тунгалаг |

2.4. Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Чоно нь эзнээ хараад өөрийн үйл лай ирж явааг мэдэн, хавтгайгаараа унаж, пид пид хийлгэн цохих тоолонд нь гаслан гангинана. | A. Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс” |
| 2. Тэр лав манай бирвааз мөн дөг өө. Монш чинь ханаад нь тасарч урсаад морьтын гарманд хайрдсанаас зайлахгүй дэг. | B. Ц.Дамдинсүрэн “Багш шавь хоёр” |
| 3. Эрчээрээ давхиад гол дээр очъё. Усны эрэг дээр их сайхан байгаа. Цамба мөд ирэхгүй. | |
| 4. Чүлтэм хаанаас олсныг мэдэхгүй, өврөөсөө нэг улцгар дурдан алчуур гаргаж өгөхөд Цэрмаагийн дотор Мядагмаагийн торгон дээлийг өмссөнөөс илүү сайхан санагдаж байв. | C. П.Пүрэвсүрэн “Өшөө”<br>D. С.Эрдэнэ “Хулан бид хоёр” |
| 5. Цэцэгмаа хотод дэмий сууж эрдэм сурч чадалгүй, цагийг талаар өнгөрүүлснээ сая ойлгож мэдлээ. | E. Д.Мягмар “Үер” |

## ХУВИЛБАР D

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Нутгийн тэнхээ

Дөчин таван оны чөлөөлөх дайны үед тэсрэлтэд битүү бэртээд дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олж хээрийн эмнэлэгт сувилсаар засрал олж амжаагүй тул тэр чигт нь нүүлгэн авч явжээ.

Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч хэл орсонгүй. Харин аажимдаа сонсгол орж орос үг дуулсаар орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ.

Төөрч будилсаар арваад жилийн дараа нутагтаа ирээд ганц ч монгол үг мэдэхгүй байхад нь нутгийн хүмүүс гайхаж, зарим нь ч “Ихээхэн маяг сураа шив дээ!” хэмээн муучилж гэнэ.

Танил найз нар нь унаа машин олоод төрсөн нутагт нь аваачвал мань хүн Бумбат Улаан Өндөр хэмээх нутгийнхаа уулыг гэнэт таниад баярлахдаа:

Ээ ээ Бумбуут Улан Уундуур! хэмээн хашхирч, далан зад үсрэх мэт болоод монгол хэлээр ярьдаг болсон гэдэг. *(Ж.Лхагва)*

1. Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг олоорой.
   1. Монгол хэлээр ярьдаг болсон гэдэг.
   2. Засрал олж амжаагүй тул тэр чигт нь нүүлгэн авч явжээ.
   3. Орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ.
   4. Дөчин таван оны чөлөөлөх дайны үед тэсрэлтэд битүү бэртээд...
   5. Ихээхэн маяг сураа шив дээ!

   A. 4, 2, 5, 3, 1　　B. 4, 2, 3, 1, 5　　C. 4, 2, 5, 1, 3
   D. 4, 2, 3, 5, 1　　E. 4, 3, 2, 5, 1
2. Дээрх эхийн жинхэнэ нэрийг утгаар нь зүйлчилбэл ямар утгын зүйлчлэл байхгүй байна вэ?
   A. Хүний зүйл　　B. Гариг эрхсийн зүйл　　C. Сэтгэхүйн зүйл
   D. Ургамлын зүйл　　E. Хүний бүтээсэн зүй
3. Дээрх эхийн хэв маягийг тодорхойлно уу.
   A. Тайлбарламж　　B. Тоочимж　　C. Хүүрнэмж
   D. Эргэцүүлэмж　　E. Учирламж
4. Дээрх эх найруулгын ямар төрлөөр бичигдсэн байна вэ?
   A. Албан бичгийн найруулга　　B. Эрдэм шинжилгээний найруулга
   C. Уран зохиолын найруулга　　D. Сонин нийтлэлийн найруулга
   E. Ярианы найруулга
5. Дээрх эхийн сэдвийг олоорой.
   A. Хүний тусч энэрэнгүй сэтгэлийн тухай　　B. Дайны хор уршгийн тухай
   C. Нутгаа санасан хүний тухай　　D. Орос Монголын ахан дүүсийн харилцаа
   E. Төрсөн нутгийн тухай
6. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
   A. Дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олж хээрийн эмнэлэгт сувилсаар...
   B. Төөрч будилсаар арваад жилийн дараа нутагтаа ирээд...
   C. Орос үг дуулсаар орос хэл сурсан боловч монгол хэл нь таг мартагджээ.
   D. Ээ ээ Бумбуут Улан Уундуур! хэмээн хашхирч, далан зад үсрэх мэт болоод монгол хэлээр ярьдаг болсон гэдэг.
   E. Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч хэл орсонгүй.
7. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ?
   A. “Дөчин таван оны... авч явжээ”, “Тэр... хэл орсонгүй”, “Харин... мартагджээ”, “Төөрч... муучилж гэнэ”, “Танил найз... болсон гэдэг” гэсэн 5 цогцолбор
   B. “Дөчин таван оны... авч явжээ”, “Тэр... мартагджээ”, “Төөрч... муучилж гэнэ”, “Танил найз... болсон гэдэг” гэсэн 4 цогцолбор
   C. “Дөчин таван оны... авч явжээ”, “Тэр... мартагджээ”, “Төөрч... болсон гэдэг” гэсэн 3 цогцолбор
   D. “Дөчин таван оны... мартагджээ”, “Төөрч... болсон гэдэг” гэсэн 2 цогцолбор
   E. 1 цогцолбороос бүтсэн бичил эх
8. Дээрх эхийн тулгуур үгсийг зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
   A. Дайн, байлдагч, тэсрэлт, эмнэлэг, сонсгол, хэл, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, хүмүүс, маяг
   B. Дайн, байлдагч, эмнэлэг, засрал, сонсгол, хэл, ухаан, үг, маяг, уул, хүмүүс
   C. Дайн, байлдагч, тэсрэлт, шарх, эмнэлэг, сонсгол, Сибир, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, машин
   D. Дайн, байлдагч, зөвлөлтийн цэргийн анги, сонсгол, хэл, ухаан, үг, Бумбат Улаан Өндөр, маяг, унаа, нутаг
   E. Дайн, байлдагч, шарх, зөвлөлтийн цэргийн анги, ухаан, монгол, орос, хэл, үг, нутаг, Бумбат Улаан-Өндөр
9. Дараах өгүүлбэрээс шинэ санаа илэрхийлсэн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.
   “Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон боловч...”
   A. Адилтгал　　B. Ихэсгэл　　C. Төлөөлөл　　D. Зүйрлэл　　E. Хүншүүлэл
10. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
   Эхийн төгс санаанд зохиогчийн үзэл бодол, хүсэл санаа, сэтгэлийн аяс хөдлөлийг илтгэсэн баймж үнэлэмж ил ба далд шурган орсныг.......................................... гэнэ.
   A. Төрсөн санаа　　B. Гол санаа　　C. Зорьсон санаа
   D. Шинэ санаа　　E. Төгс санаа

11. Бүгд баймж, үнэлэмж, сэтгэл хөдлөлийн өнгө аяс илтгэсэн хэсгийг олоорой.
    A. ...ганц ч, ...зарим нь ч, ...сураа шив дээ!, ...Ээ ээ
    B. ...аажимдаа, ...мэдэхгүй байхад нь, ...ганц ч, ...Ээ ээ, ...баярлахдаа
    C. ...муучилж гэнэ, ...гэнэт, ...сураа шив дээ!, ...ухаангүй
    D. ...таг мартагджээ, ...тэр чигт нь, ...таниад, ...хашхирч
    E. ...ганц ч, ...сураа шив дээ!, ...ярьдаг, ...зад үсрэх
12. Дараах үгсийн аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ?
    A. Унаа машин B. Тэр байлдагч C. Төөрч будил
    D. Жилийн дараа E. Мэдэхгүй байхад
13. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглан, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
    Хэвтэж байсан, дайны талбар, амжаагүй тул, монгол байлдагч, ярьдаг болсон, хээрийн эмнэлэг, ...............
    A. Цэргийн анги B. Арваад жил C. Нутгийн уул
    D. Жилийн дараа E. Монгол үг
14. "Дайны талбарт **ухаангүй** хэвтэж байсан" гэсэн өгүүлбэрийн онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
    A. Хамжсан тодотгол гишүүн B. Өгүүлэхүүн гишүүн
    C. Шууд бус тусагдахуун гишүүн D. Үйлийн тодотгол гишүүн E. Байц гишүүн
15. "Тэсрэлтэд битүү бэртээд дайны талбарт ухаангүй хэвтэж байсан" гэсэн өгүүлбэрээс захын дэлгэрүүлэгч гишүүнийг олоорой.
    A. Тэсрэлтэд B. Ухаангүй C. Битүү D. Дайны E. Талбарт
16. "Танил найз нар нь унаа машин олов" гэсэн өгүүлбэрт үл тохирох шинжийг олоорой.
    A. Бүтэц B. Хүүрнэх C. Хоёр бүрэлдэхүүнт D. Энгийн E. Дэлгэрэнгүй
17. "Дөчин таван оны чөлөөлөх дайны үед тэсрэлтэд битүү бэртэв" гэсэн өгүүлбэрт тохирох тодорхойлолтыг сонгоорой.
    A. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй УНӨ
    B. Хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
    C. Үйлийн тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
    E. Байц гишүүн өгүүлбэртэй УНӨ
    E. Олон гишүүн өгүүлбэртэй УНӨ
18. "Дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олжээ" гэсэн өгүүлбэрийн тонгоргол аль вэ?
    A. Зөвлөлтийн цэргийн анги монгол байлдагчийг олжээ.
    B. Дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олсон нь сайн юм болжээ.
    C. Дайны талбарт ухаангүй хэвтэж байсан монгол байлдагчийг зөвлөлтийн цэргийн анги олсон юм уу?
    D. Монгол байлдагч дайны талбарт ухаангүй хэвтэж байжээ.
    E. Зөвлөлтийн цэргийн ангийн олсон монгол байлдагч дайны талбарт ухаангүй хэвтэж байжээ.
19. "Байлдагч дайны үед тэсрэлтэд битүү бэртжээ" гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг зөв тодорхойлсныг олоорой.
    A. Байлдагч бэртэнэ B. Байлдагч битүү бэртэнэ
    C. Байлдагч тэсрэлтэд бэртжээ D. Байлдагч дайнд бэртжээ
    E. Байлдагч дайны үед тэсрэлтэд бэртжээ
20. Дараах зэргэдийг ажиглан, төсөөт зэргэдийг олоорой.
    A. Хүн гэмээ мэдэхгүй, Тэмээ гэдгэрээ мэдэхгүй
    B. Ус дусаах үүлийг улс хотлоор таашаа, Хөлс цутгах нарыг хэн бүгдээр зэмлэх
    C. Үгийн өвгөн утгын таяг тулмуй, Утгын өвгөн үгийн таяг тулмуй
    D. Өглөгч ядуу түмэнд нэртэй, Харамч чадуу гүрэнд хочтой
    E. Эцсэн моринд ташуур олон, Зүдэрсэн хүнд ноён олон
21. "Ээ ээ Бумбуут Улан Уундуур! хэмээн хашхирч, далан зад үсрэх мэт болоод монгол хэлээр ярьдаг болсон гэдэг" гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маяг юу вэ?
    A. Чанга дуугаар хашхирахыг далан зад үсэрнэ гэж хэтрүүлсэн
    B. Чанга дуугаар хашхирахыг далан зад үсэрнэ гэж адилтгасан
    C. Чанга дуугаар хашхирахыг далан зад үсэрнэ гэж зүйрлэсэн
    D. Байлдагчийн монгол хэлээрээ гэнэт ярихыг далан зад үсрэхтэй адилтган ихэсгэсэн
    E. Байлдагчийн монгол хэлээрээ гэнэт ярихыг далан зад үсрэхтэй зүйрлэн ихэсгэсэн
22. "Тэр шархтай байлдагч Сибирийн гүнд ухаан орсон болович хэл орсонгүй" гэсэн өгүүлбэрийн "тэр" гэдэг холбоос ямар холбоос вэ?
    A. Шалтгааны утгатай гадаад холбоос B. Зорилгын утгатай гадаад холбоос
    C. Үйлийг төлөөлсөн холбоос D. Хүнийг төлөөлсөн холбоос
    E. Ялгах утгатай гадаад холбоос

23. Эхний хоёр баганыг харгалзуулан гуравдугаар баганын шинжтэй тохируулаарай.

| | | |
|---|---|---|
| 1. Төөрч | A. Байлдагч | I. Үйлийн найрах холбоо |
| 2. Монгол | B. Эмнэлэг | II. Нэрийн хамжих холбоо |
| 3. Битүү | C. Будилах | III. Үйлийн хамжих холбоо |
| 4. Хээрийн | D. Бэртэх | IV. Нэрийн найрах холбоо |

A. (1.A.I), (3.D.III), (4.B.IV), (2.C.II) B. ( 2.A.II), (3.B.III), (1.C.I), (4.D.IV)
C. (4.D.I), (2.B.II), (1.C.III), (3.A.IV) D. (1.D.I), (3.B.IV), (2.C.II), (4.A.III)
E. (3.D.III), (1.C.I), (2.A.II), (4.B.IV)

24. Дараах үгсийг ажиглан төрөл биш үгийг олоорой.
A. Олбор B. Олбог C. Олдвор D. Олз E. Ололт

25. “Аваачвал” гэсэн үгийг үеэр зөв тасалсныг олоорой.
A. А - ваач - вал B. Ав - аач - вал C. Аваач - вал
D. А - ваа - ч - вал E. Ав - аа - ч - вал

26. “Төрсөн нутагт нь **аваачвал** мань хүн Бумбат Улаан-Өндөр хэмээх нутгийнхаа уулыг гэнэт таниад...” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль нөхцөлөөр солин найруулбал өгүүлбэрийн утга өөрчлөгдөхгүй вэ?
A. -нгаа [4] B. -ж C. -тал [4] D. -саар [4] E. -аад [4]

27. Аль үг нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалж байна вэ?
A. Муухай харах B. Царай харах C. Морь харах
D. Хүүхэд харах E. Гар харах

28. Дараах жагсаалтад үгийн сангийн найруулгын үүргээр аль үг нь илүүц байна вэ?
A. Мэлмий B. Лагшин C. Өргөө D. бие E. Тэргүүн

29. “Түргэвчилбэл” гэсэн үгийг бүтцээр нь зөв задалсныг олоорой.
A. Түргэ + вч + л + 0 + 0 + бэл B. Түргэн + чил + 0 + 0 + бэл
C. Түргэн + вч + л + 0 + 0 + бэл D. Түргэ + вчил + 0 + 0 + бэл
E. Түр + гэн + чил + 0 + 0 + бэл

30. Дараах үгсээс бүгд зөв бичсэн бүлэг үгийг олоорой.
A. Шуугьж, айргийг, таслалын, тамгалъя, түргэдэх
B. Шаагиж, таргийг, зөвөллөөр, үсэглэе, нарийдах
C. Баагьж, нутгын, аяллын, хавтаслая, өргөдөх
D. Угьж, будгын, уучлалаар, хайчилъя, уртдах
E. Нуугиж, худгийн, хөдөллөөс, тааруулъя, богинодох

31. “Нутгийн, утсаар, өндрөөс, нөхөд, цэргийн” гэсэн үгсийг бүтээврээр задалж үзээд бүтээврийн ямар хувиргал болохыг тодорхойлоорой.
A. Хураах B. Дэлгэрүүлэх C. Салаалах
D. Тонгоргох E. Аль нь ч биш

32. “Төөрч будилсаар арваад жилийн дараа нутагтаа ирээд ганц ч монгол үг мэдэхгүй байхад нь нутгийн хүмүүс гайхаж, зарим нь ч “Ихээхэн маяг сураа шив дээ! хэмээн муучилж гэнэ” гэсэн өгүүлбэрт тусах, үүсмэл биш үйл үг хэд байна вэ?
A. 6 B. 5 C. 4 D. 3 E. 2

33. “Зөвлөлтийн цэрэг” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утгыг олоорой.
A. Бүхлийн хэсгийг заасан утга B. Уул юм хэний, юуны эзэмшилд буй утга
C. Шинж чанар заасан утга D. Тоо ширхэг, хэмжээ заасан утга
E. Орших байр, орон зай заасан утга

34. Дараах өгүүлбэрийг уншаад аман зохиолын ямар төрөл зүйл болохыг тодорхойлоорой.

A. B. C. D. E.



35. “Хогийн шүүр” гэсэн холбоо үгийн “шүүр” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A. B. C. D. E.



**36.** “  ” гэсэн үгэнд бүгд тохирох нөхцөлтэй хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



37. Бүх үг нь холбох эгшгийн дүрмээр бичигдсэн хэсгийг олоорой.

A. B. C. D. E.



38. “Монголын нууц товчоо” зохиолын тавдугаар бүлэгт Ван ханд хандан Тэмүжиний тухай хэлэхдээ
“Ам хэлэндээ
Аав хөвүүн гэдэг болович
Авир санаа нь
Адвиш өөр биш үү” гэж хэн хэлдэг вэ?
   A. Алтан B. Хучар C. Жамуха
   D. Сэнгүм E. Өвөгжин ноёхон
39. Д.Равжаагийн “Ичиг ичиг” шүлэгт дэвшүүлсэн гол санаа нь юу вэ?
   A. Ард түмний аж амьдралын хүнд хэцүү байдлыг дүрсэлсэн
   B. Хүний амьдралын эрээн бараан, ёс суртахууны доголдлыг шүүмжилсэн
   C. Ихэс дээдэс, лам нарын эрх ашгийг хамгаалж дэмжсэн
   D. Байгаль улирлын байдлыг хүн, амьтны настай жишин харьцуулсан
   E. Аливаа зүйлийг хийхдээ сэтгэлээсээ хийж байхыг сургасан
40. Ч.Лодойдамба “Хугараагүй ноён нуруу” туужид “Дорж гуайг харахад их үер юм уу, салхинд хэсэг мөчрөө хугалуулсан болович ялж гараад навч дэлгэн байгаа бүдүүн улиас шиг байв” хэмээн дүрсэлсний учир юу вэ?
   A. Модны мөчир хугалж болохгүй гэсэн утгыг гаргажээ
   B. Дорж гуай том биетэй эрэгтэй хүн учраас бүдүүн улиастай адилтган бичжээ
   C. Дорж гуайн амьдралын ноён нуруу хугараагүй, хугалж дийлэх хүч ч байхгүй юм гэдгийг бүдүүн улиасаар дүрслэн бичжээ
   D. Дорж гуайн амьдралын ноён нуруу хугарсан болович эргээд сэргэж байгаа тухай бүдүүн улиасаар дүрслэн гаргажээ
   E. Байгалийн зураглалыг дүрслэн гаргажээ

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Чөлөөт бус холбоо үгийн хэв шинжийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. ҮС + ҮС | A. Хөхөө шувуу донгодож байна |
| 2. БЗ + ХЗ | B. Мөнгөн өвлийн нэгэн шөнө |
| 3. ХЗ + ҮС | C. Төмөр замын өртөөн дээр |
| 4. УЗ + БЗ | D. Өдөр шөнөгүй ажиллаж хөдөлмөрлөнө |
| 5. ҮС + ХЗ | E. Гэрийн гадна гэдэн годон |

2.2. Хэлцүүдийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Зангуу тариад эсгий хийнэ | A. Айсан хүнд аргал хөдөлнө |
| 2. Өнгөнд хөлбөрч, өөхөнд умбах | B. Алтны дэргэдэх гууль шарлана |
| 3. Цочсон нохой цохноос айна | C. Сүүдрийг барьж салхийг харвах |
| 4. Бух дагаж бяруу өвсөнд хүрнэ | D. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх |
| 5. Өдөр алдаад шөнө тэмтрэх | E. Аав ээжийн алган дээр бөмбөрөх |

2.3. Найруулгын төрлийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Албан бичгийн найруулга | A. Өсвөр үеийнхний хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах тэмцээн ирэх долоо хоногт болно |
| 2. Сонин нийтлэлийн найруулга шингэж | B. Айраг боловсруулах үед уургийн зүйл задарч хялбар боловсрох нэгдлүүд болж хувирна |
| 3. Уран зохиолын найруулга гадаад | C. Төрийн албан ёсны хэлэнд дүйх үг, нэр томьёо байхад үг, нэр томьёо хэрэглэхийг хориглоно |
| 4. Ярианы найруулга | D. Эх орондоо хайргүй адгийн шааруул байна уу? |
| 5. Эрдэм шинжилгээний найруулга | E. Нарны гэрэл хурц болоход, Үүлгүй бол нэн сайн |

2.4. Дараах зохиолын нэрсийг ишлэлтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Баруун дамнуурчны ба гандангийн дэнж хоёрын хооронд нэг нарийхан шинэ зам нээгдэв. | A. Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь” |
| 2. Төрж өссөн нутаг нь гэвэл энэ Дулаан хайрхан мөн. Анх төрөхдөө ар бэлд нь төрөв. Идэр залуудаа эгц цавчим ирмэгт нь орогноод эцсийн гурван жил арга буюу авирах хөлийн чадал доройтсон учир өвөр энгэрт нь хоргодох болжээ. | B. Ц.Дамдинсүрэн “Багш шавь хоёр“ |
| 3. “Гучин нэгэн алд“ гэж давтан хэлснээ - Дөчин жил усны эрэг сахисан гэхэд даанч дээ. Бас болоогүй байна. | C. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” |
| 4. Цэцэгмаагийн бие суларч доройтсон тул, хэрэв цэцэгтэй адилтгая гэвэл гудамжны тоосонд дарагдаж, хөлд гишгэгдсэн барагтайхан цэцэг шиг болжээ. | D. С.Эрдэнэ “Хулан Цамба хоёр” |
| 5. Одоо Чингисийн дүрийг санагдуулах юм юу ч алга. Ердөө л нэг тарган шар өвгөн “Ямар гайтай цас гээч вэ. Уул хөвчид явахын арга алга. Зуд болдгоо боллоо. Арай чүү гэж ганц мэгж алаад...” гэж үглэсээр буу сумаа өлгөв. | E.Д.Мягмар “Үер” |

# 2010 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

| Нэгдүгээр хэсэг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ХУВИЛБАР А | | ХУВИЛБАР В | | ХУВИЛБАР С | | ХУВИЛБАР D | |
| 1 | C | 1 | A | 1 | E | 1 | D |
| 2 | B | 2 | C | 2 | D | 2 | D |
| 3 | B | 3 | E | 3 | B | 3 | C |
| 4 | B | 4 | A | 4 | C | 4 | C |
| 5 | A | 5 | D | 5 | C | 5 | E |
| 6 | B | 6 | D | 6 | D | 6 | D |
| 7 | C | 7 | E | 7 | B | 7 | B |
| 8 | D | 8 | B | 8 | A | 8 | E |
| 9 | C | 9 | A | 9 | C | 9 | C |
| 10 | B | 10 | D | 10 | B | 10 | C |
| 11 | A | 11 | A | 11 | E | 11 | A |
| 12 | C | 12 | B | 12 | B | 12 | B |
| 13 | E | 13 | D | 13 | D | 13 | D |
| 14 | C | 14 | D | 14 | E | 14 | D |
| 15 | A | 15 | A | 15 | D | 15 | E |
| 16 | D | 16 | E | 16 | D | 16 | C |
| 17 | E | 17 | A | 17 | B | 17 | B |
| 18 | E | 18 | D | 18 | E | 18 | E |
| 19 | D | 19 | C | 19 | D | 19 | A |
| 20 | C | 20 | A | 20 | E | 20 | C |
| 21 | E | 21 | C | 21 | B | 21 | E |
| 22 | E | 22 | E | 22 | D | 22 | E |
| 23 | B | 23 | D | 23 | C | 23 | E |
| 24 | E | 24 | C | 24 | C | 24 | B |
| 25 | C | 25 | A | 25 | D | 25 | A |
| 26 | B | 26 | A | 26 | B | 26 | C |
| 27 | E | 27 | A | 27 | E | 27 | A |
| 28 | B | 28 | E | 28 | E | 28 | D |
| 29 | C | 29 | B | 29 | C | 29 | B |
| 30 | D | 30 | A | 30 | C | 30 | A |
| 31 | B | 31 | D | 31 | B | 31 | A |
| 32 | D | 32 | C | 32 | B | 32 | D |
| 33 | A | 33 | C | 33 | E | 33 | B |
| 34 | E | 34 | E | 34 | E | 34 | E |
| 35 | B | 35 | C | 35 | B | 35 | B |
| 36 | B | 36 | E | 36 | D | 36 | B |
| 37 | E | 37 | D | 37 | C | 37 | D |
| 38 | C | 38 | E | 38 | D | 38 | C |
| 39 | C | 39 | A | 39 | B | 39 | B |
| 40 | C | 40 | B | 40 | C | 40 | C |

| Хоёрдугаар хэсэг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1** | 1c2d3a4e5b | **2.1** | 1c2b3e4a5d | **2.1** | 1d2e3a4b5c | **2.1** | 1d2a3e4b5c |
| **2.2** | 1d2c3b4e5a | **2.2** | 1b2d3e4a5c | **2.2** | 1e2d3a4b5c | **2.2** | 1c2e3a4b5d |
| **2.3** | 1e2c3d4a5b | **2.3** | 1e2c3a4b5d | **2.3** | 1a2d3e4c5b | **2.3** | 1c2a3e4d5b |
| **2.4** | 1c2a3d4e5b | **2.4** | 1c2a3d4e5b | **2.4** | 1c2e3d4a5b | **2.4** | 1c2a3e4b5d |